



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 1/04

Жаргалтхаан сум

Гамшгаас хамгаалах орон тооны бус
штабын бүрэлдэхүүнийг батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 39 дүгээр зүйлийн 39.8, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.2.4 дэх заалтууд, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жаргалтхаан сумын ерөнхий боловсролын сургуулийн хэвийн үйл ажиллагааг хангах, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий гамшгаас хамгаалах орон тооны бус штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын албан хаагчид, орон тооны бус штабын гишүүдийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах, шаардлагатай баримт бичгүүдийг тухай бүр шинэчилж, холбогдох хууль тогтмолжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг гамшгаас хамгаалах орон тооны бус штабын дарга (Д.Чинбат)-д даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтад заасны дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, орон тооны бус штабад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж, ажиллах нөхцөлөөр хангахыг нягтлан бодогч (Г.Урансүх)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ТӨМӨРБААТАР



D/Tushaal-2024

232401007